

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 6 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 6 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	/тоогоор/			
		2010-V	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-VI
1	Даатгалын компани	16			16
2	Даатгалын компанийн салбар	134			134
3	Даатгалын төлөөлөгч	2006			2006
4	Даатгалын зуучлагч	7	1 ¹		8
5	Даатгалын хохирол үнэлэгч	6			6
6	Актуарч	10			10
7	Аудитын компани	20			20
8	Аудитор	46			46
9	Бусад өөрчлөлт		4 ²		

Тайлант үед даатгалын компани, тэдгээрийн салбар, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч, актуарч, аудитын компани болон аудиторуудын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор “Жомолхари” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, даатгалын зуучлагч компанийн тоо 2010 оны 6 дугаар сарын байдлаар 8 болсон байна.

²Хорооны 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 167 дугаар тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” компанид тэтгэврийн даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосон.

²Хорооны 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 168 дугаар тогтоолоор “Түшиг даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Ц.Баттулга, тэргүүн дэд захирлаар Б.Мөнхтуяа, 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 200 дугаар тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн дэд захирлаар Д.Ганбаатар нарыг томилохыг тус тус зөвшөөрсөн байна.

²Хорооны 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор “Миг даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрснөөр тус компани 10 хувь нийлүүлэгчийн 1.0 тэрбум төгрөгийн дүрмийн сантай болсон байна.


2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2010 оны 6 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		Өөрчлөлт /Хувиар/
		2009-VI	2010-VI	
1	Даатгалын нийт хураамж	2,838,837,239.3	5,119,896,304.1	80.3 %
2	Олгосон нийт нөхөн төлбөр	411,527,290.0	417,340,949.0	1.4 %
3	Давхар даатгалд төлсөн хураамж	182,185,541.7	1,903,502,331.0	944.8 %
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	12,321	11,423	
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	24,565,000,000.0	280,881,591,000.0	1,043.4 %
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	21,245,607.0	41,276,100.0	94.2 %

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж, сая төгрөгөөр



2010 оны 6 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 2,281.0 сая төгрөгөөр буюу 80.3 хувиар, олгосон даатгалын нөхөн төлбөр 5.8 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар, давхар даатгалд төлсөн хураамж 1,721.4 сая төгрөгөөр буюу 944.8 хувиар тус тус өссөн байна.

Тайлант үед шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн 43.1 хувь буюу 822.1 сая төгрөгийг “Бодь даатгал” ХХК, 29.3 хувь буюу 559.1 сая төгрөгийг “Прайм генерал даатгал” ХХК, 20.9 хувь буюу 397.9 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК шилжүүлсэн байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	2009-VI	2010-VI	/төгрөгөөр/ Өөрчлөлт /Хувиар/
1	Даатгалын нийт хураамж	1,646,849.00	8,677,339.00	426.9 %
2	Олгосон нийт нөхөн төлбөр	296,000.00	2,064,698.00	597.5 %
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	-	
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	4	3	
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд		2	
	-Байгууллагын хугацаат даатгалд		1	
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		-	
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	50,000,000.00	10,000,000.00	-80 %
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	296,000.00	220,000.00	-25.6 %

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 6 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 7.0 сая төгрөгөөр буюу 426.9 хувиар нэмэгдэж, мөн 2.0 сая төгрөгийн нөхөн төлбөр гарч урд байснаас 597.5 хувиар нэмэгдсэн нь хойшид нөхөн төлбөр ихээр нэмэгдэх шинжтэй байгааг харуулж байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	2010-IV	2010-V	/төгрөгөөр/ 2010-VI
1	Даатгагчид дамжуулан шилжүүлсэн даатгалын хураамж	103,228,184.09	49,451,418.05	29,465,076.46
2	Даатгалын зуучлагчийн орлого	30,997,899.72	12,533,780.34	16,515,077.77
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	50	16	143
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3,567,401,648.00	3,420,609,952.24	3,009,477,842.00

2010 оны 6 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 143 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучлан 16.5 сая төгрөгийн зуучлалын орлого олж, даатгалын зуучлалын орлого өмнөх сарынхаас 31.7 хувиар өссөн байна.

Даатгалын зуучлагчийн орлогын 26.1 хувийг “Аме” ХХК, 22.4 хувийг “Ачит ундарга” ХХК, 19.1 хувийг “Лоялти солюшн” ХХК, 18.8 хувийг “Асимон брокерс” ХХК, 13.6 хувийг “Реннесанс групп” ХХК төвлөрүүлэн ажиллаж, “Эм Жи Ай Би” ХХК, “Скай эрдэнэ” ХХК, “Жомолхари” ХХК даатгалын зуучлалын орлого олоогүй байна.

2010.7.15